

“УЛААНСАН” ХК

2024 оны 08 сарын 16

№ 24/02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ


*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурал зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Компанийн дүрмийн 8.2, 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Улаансан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Улаансан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг **2024 оны 09 сарын 27-ны өдрийн 15:00 цагт, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай - 2, Сентрал Тауэр 17 давхарт** хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Гуравдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Дөрөвдүгээр хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг Тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 09 сарын 09-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2024 оны 08 сарын 19-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 08 сарын 21-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2024 оны 09 сарын 05-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг холбогдох бусад баримт бичгийг бэлэн болгож, 2024 оны 08 сарын 26-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2024 оны 09 сарын 26-ны өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.
8. Хурлын даргаар Өнөрбаян овогтой Ашхүүг томилсугай.

“УЛААНСАН” ХК

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга:
Ө.Ашхүү
Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
С.Нямгэрэл
О.Нандинцэцэг
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Тооллогын комиссын дарга:
Ө. Бямбагэрэл, Хуулийн зөвлөх
Тооллогын комиссын гишүүд:
Т. Батбаяр, Дилер
У.Намуун, Хөрөнгө оруулалтын банкны хэлтсийн ахлах
11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг гүйцэтгэх захирал Г.Лхагвасүрэн -д даалгасугай.



“УЛААНСАН” ХК

2024 оны 08 сарын 16

№ 24/04

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирал томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн “Улаансан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Өнөрбаян овогтой Ашхүү-г Компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалд томилсугай.
2. О.Ашхүүтэй байгуулах хөдөлмөрийн гэрээнд заасан хэмжээгээр цалин хөлсийг тогтоож, холбогдох татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг суутган олгож байхыг Компанийн нягтлан бодогчид даалгасугай.
3. О.Ашхүүтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ДАРГА



Ц.ЭНХЦАГ